



ХЭНТИЙ АЙМАГ  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/222

Өмнөдэлгэр сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/01 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зарлагдсан дуудлага худалдааны ялагч болсон “Пролог системс” ХХК (5810973)-д тус сумын 7 дугаар баг, Шар тал гэх газарт мод үржүүлгийн зориулалтаар 30000м<sup>2</sup> газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээний дагуу эзэмшихийг газар эзэмшигч “Пролог системс” ХХК-д даалгасугай.

3.Газар эзэмшилтэд байнгын хяналт тавьж, газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Гурванбаян тосгоны газрын даамал (Б.Энхтайван)-д үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР